



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-24</i>

---

<i>1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хургуулна/</i>	<i>4-24</i>
---	-------------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
08 дугаар сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

**Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат;  
Тасалсан: Ш.Бямбасүрэн.**

**Нэг. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийн газрын дарга Д.Баттогтох, Шинжлэх ухаан, технологийн сангийн Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонжаргал, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Авид, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Б.Баярбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, мөн хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд, Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Э.Билэгт, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч О.Мэндсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Санхүү-нийцлийн

аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Г.Дамдинням, Б.Найдалаа, Д.Рэгдэл, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, О.Батнайрамдал, Ж.Галбадрах нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 15 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 38 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,  
Пүрэв гараг Төрийн ордон “Үндсэн  
хууль” танхим 12 цаг 18 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ч.Ундрам:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Отгоншарын Батнайрамдал 10 дугаар тойрог ирсэн байна. Дуламын Бум-Очир жагсаалт ирсэн байна. Шинэбаярын Бямбасүрэн ирээгүй байна 6 дугаар тойрог, Жанчивын Галбадрах жагсаалт ирсэн байна, Амгаланбаатарын Ганбаатар Жагсаалт өвчтэй, Гонгорын Дамдинням 5 дугаар тойрог ирсэн байна. Бадрахын найдлаа жагсаалт ирсэн байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа жагсаалт өвчтэй, Дүгэрийн Рэгдэл жагсаалт ирсэн байна, Отгоны Саранчулуун жагсаалт ирсэн байна, Мягмардашийн Сарнай жагсаалт ирсэн байна, Чинбатын Ундрам 5 дугаар тойрог ирсэн байна, Ганбатын Хосбаяр 1 дүгээр тойрог ирээгүй байна, Бадарчийн Хэрлэн жагсаалт ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэбат жагсаалт өвчтэй. ирц 15 хүнээс 10 хүн ирсэн 66.7 хувьтай байгаа учраас одоо хуралдааныг эхлүүлэе ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их

Хурлын тогтоолын төсөл ийм нэг асуудал байгаа юм байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүдээс санал, асуулт байна уу? Хэлэлцэх асуудлаа баталъя. Ер нь бол тийм. Бүгдээрээ л яачихвал шүү дээ. Би ямар ч л байсан явж байя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн сайд Жавхлан орж ирж байгаа. Боловсролын сайд Наранбаяр байна уу? Ирчихсэн байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах байна уу? Одоохондоо ирээгүй байна ирж байх ёстой. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамныхан орж ирээрэй. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал байхгүй байна. Энэ Сангийн яамныхан иртэл хүлээхээс хүлээхээс өөр аргагүй болох нь байна шүү дээ. Ерөнхий аудитор орж ирээгүй байх шиг байна. Орж ирээгүй байна. Энэ хүмүүсийг орж ирэхгүй бол одоо асуудлаа яаж хэлэлцэх вэ дээ жоохон хүлээе.

Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамнаас хүн байна уу? Бас ирчихсэн байгаа юм байна. Даваажаргал дарга байна уу? Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл урлагийн БХЗГ-ын дарга Сэргэлэн, Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын БХЗГ-ын дарга Батдорж, Биеийн тамир

спортын улсын хорооны дарга Баттулга ирсэн байна. Биеийн тамир спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Гэрэл, Аялал жуулчлалын БХЗГ-ын ахлах шинжээч Болормаа, Биеийн тамир спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэрэнболд, Үндэсний шигшээ багийн Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Билэгт, Соёлын өвийн БХЗГ-ын шинжээч Бямбасайхан. Эдгээр хүмүүс Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирсэн байна. Боловсролын яамнаас Батжаргал дарга байна уу? Ирж байгаа юу? Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг ирсэн байна. Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байна уу? Байхгүй байна. Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамыг хүлээе.

Сангийн яамны бусад хүмүүс нь ирсэн юм уу Цогбадрах, Сонор, Мөнхсүх гээд байхгүй байна шүү. Сангийн яамнаас нэг ч хүн алга байхгүй байна ш дээ? Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын сайд, боомтын захиргааны улсын хорооны дарга Буяагийн Тулга орж ирсэн байна. Тулга сайд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг танилцуулна аа.

**Б.Тулга:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Боловсролын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын нийт 2325 байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 3 их наяд 457.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч урсгал зардалд 2 их наяд 748.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 705.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна аа. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 87.8 хувь буюу 3 их наяд 37.2 тэрбум төгрөгийг, Боловсролын сайд 12.2 хувь буюу 420.4 тэрбум төгрөгийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын зарлага эзэлж байна аа. Улсын төсвөөс 3 их наяд 464.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 12.8 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах

тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ч.Ундрэм:** Тулга сайдад баярлалаа. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тус хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 6 номерын микрофон өгөөрэй.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлэе.

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя аа.

1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны нэгтгэсэн тайланд нийт 18112 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 1050 байгууллагад дүгнэлт гаргаж, 751 байгууллагын аудитын төвүүдэд хамруулсан. 1812 юм байна. Шинээр байгуулагдаж үйл ажиллагаа эхлээгүй 11 байгууллага аудитад хамрагдаагүй болно. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, харьяа 964

байгууллагад өөрчлөлтгүй, 81 байгууллагад хязгаарлалттай, 3 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, нэг байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 252 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 2.8 тэрбум төгрөгийн 2531 зөрчил төлбөрийн акт тогтоож, 179.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах арилгах 743 албан шаардлага хүргүүлж, 66.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1459 зөвлөмж өгч, 3.8 тэрбум төгрөгийн 33 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж нэг асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүллээ. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 95.3 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 95.2 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж 0.1 тэрбум төгрөгийн алдааг залруулах зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 63.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 4.4 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож 33.7 тэрбум төгрөгийн 285 зөрчилд албан шаардлага, 4.4 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах, 14 албан шаардлага хүргүүлж, 25.3 тэрбум төгрөгийн зөрчилд 612 зөвлөмж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1 их наяд 684.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 529.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дүнтэй 468 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс барилга байгууламж 450.9 тэрбум төгрөг, их засвар 11.2 тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн худалдан авалт 55.5 тэрбум төгрөг, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил 1.7 тэрбум төгрөг байна. Нийт төсөл арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 98 хувьтай байна.

2. Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 459 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 101 байгууллагад дүгнэлт гаргаж, 358 байгууллагыг аудитын дүгнэлтэд хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, харьяа 83 байгууллагад өөрчлөлтгүй, 17 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитад нийт 16.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1.3 тэрбум төгрөгийн 154 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.3 тэрбум төгрөгийн 247 зөрчлийг арилгах албан шаардлага, 1.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 217 зөвлөмж өгч, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 7 албан шаардлага хүргүүлсэн. Нягтлан бодох бүртгэл хяналттай холбоотой нийт 8.1 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс 8 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 тэрбум төгрөгийн алдааг залруулах зөвлөмж өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 14.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 8.9 тэрбум төгрөгийн зөрчилд 19 тэрбум төгрөгийн акт тогтоож, 10 тэрбум төгрөгийн 104 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4.6 тэрбум төгрөгийн зөрчилд 104 зөвлөмж өгч, 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Соёлын сайдын багцад нийт 546 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 144.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 77 төсөл арга хэмжээг он дамжин хэрэгжүүлэхээр баталсан байна аа.

Нийт 77 төсөл арга хэмжээнээс 34 төсөл арга хэмжээг орон нутагт эрхийг шилжүүлж, 43 төсөл арга

хэмжээг Соёлын сайд хэрэгжүүлсэн байна. 2023 онд нийт барилга байгууламжийн 59 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс 14 барилга ашиглалтад орсон байна. Үүнд 2 музейн барилга, нэг театрын барилга, 11 соёлын төвийн барилга байна аа. Гүйцэтгэлээр нийт 73 төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт 98 хувийн гүйцэтгэлтэй байна.

3. Монгол Улсын сайд Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын эрхлэх асуудал асуудлын хүрээний байгууллагуудын 2023 онд санхүүгийн нэгдсэн тайлан, нийт 38 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 23 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, харьяа 18 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын нийт 42.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1.2 тэрбум төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.4 тэрбум төгрөгийн 30 зөрчлийг арилгах албан шаардлага, 28.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 43 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 37.3 тэрбум төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 3.7 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1.6 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт тогтоож 3.2 тэрбум төгрөгийн 18 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.5 тэрбум төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж өгсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 162.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 48.8 тэрбум төгрөгийн



санхүүжих дүнтэй 35 төсөл арга хэмжээг төлөвлөсөн. Төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 91 хувьтай байна аа.

Тус байнгын хороо аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулахыг зөвлөж байна аа.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих, хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон захиалагчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаа зөрчлийг арилгах. Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх, боловсролын зээлийн сангаас олгосон гадаад зээл болон оюутны хөнгөлөлттэй зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай эзэн холбогдошгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй илүү дутуу тайлагнасан мөртөө тусгаагүй зөрчлийг арилгах.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ч.Ундрам:** Улсын ерөнхий аудитор баярлалаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? 4 гишүүн байна Рэгдэл гишүүнээр тасаллаа. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Надад 2 багц асуулт байгаа юм. Аудитын дүгнэлт дээр бол нийтдээ төрийн 137 хуулийн этгээдээс 109 байгууллагад санхүүгийн аудит хийгдсэн юм байна. Энэ дотроос хязгаарлалттай буюу сөрөг нь нийлээд 38 дээр нэмэх нь 31 нэг ёсондоо 3-ны 1-д нь хязгаарлалттай дүгнэлт гарчээ. Яг тэр дотроо яг хязгаарлалттай дүгнэлт, санал дүгнэлт гарсан ингээд 38 төрийн байгууллагуудыг аваад үзэхээр энэ дотор одоо Монголын хамгийн том их сургуулиуд МУБИС, МУИС, СУИС, ХААИС, ШУТИС нэг ёсондоо Монголын нийт их дээд сургуульд суралцагчдын бараг 50, 60 магадгүй 70 хувь нь суралцаж байгаа. Яг энэ тавхан сургууль дээр хязгаарлалттай дүгнэлт гарсан байна л даа. Тэгэхээр өмнө жилүүд ч гэсэн бас ямар дүгнэлт гарч байсан бол. Тэгэхээр яг энэ дүгнэлтийг нь уншаагүй болохоор ерөнхий асуугдах гээд байна л даа. Тэгэхээр энэ 5 сургууль дээр одоо хязгаарлалттай дүгнэлт гарч байгаа. Яг гол 3 зүйл нь яг юу байдаг юм бол? Бодвол давхцаж байгаа болов уу л гэж бодоод байна л даа. Ер нь хязгаарлалттай санхүүгийн дүгнэлт гэдэг маань бас шууд менежментийн одоо үр дүнтэй шууд холбогдож таарна гэсэн үг.

Ялангуяа нийт Монголын их дээд сургуульд суралцаж байгаа тэр 60, 70

хувийг нь хамарч байгаа 5 сургууль дээр бид нар хязгаарлалттай дүгнэлт гарч байна гэдэг бол менежментээр бид нар үр дүнтэй байна уу? Шууд одоо ярих асуудал харагдаад байна л даа. Тэгэхээр 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт нь Засгийн газрын тусгай сангуудын тайлан бас гарчээ. Энэ дотроос онцгойлон Боловсролын зээлийн сангийн асуудлыг хөндмөөр байна. Ер нь сүүлийн 10 жил Боловсролын зээлийн сантай холбоотой олон асуудлууд бол ил тод болсон. Тэр дундаа яг энд дурдсанаар бол нийтдээ багцлаад хэлэхэд Боловсролын зээлийн сан дээр энэ жилийн аудитын дүгнэлт дээр бараг 120 орчим тэрбум төгрөгийн асуудал хөндөгдсөн байна л даа. Тэгэхээр ер нь жил болгоны сүүлийн 10 жилийн аудитын дүгнэлтүүдийг Боловсролын зээлийн сан дээр бүгдийг нь маш сайн уншиж байсан. Энэ асуудлууд бол байнга гарч ирсээр байсан. Нийтдээ энэ 120 тэрбум төгрөгийн авлага ер нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй гэсэн дүгнэлт сүүлийн 10 жил гарсан. Харин хариу үйлдэл ерөөсөө гарч байгаагүй л дээ. Тэгэхээр энэ удаагийн аудитын дүгнэлт гэлтгүй сүүлийн 10 жил яг адилхан асуудлууд энэ аудитын дүгнэлт дээр дандаа хөндөгдөж байсан байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас энэ асуудал ингээд дахиад л аудитын дүгнэлтийн нэг хэсэг болоод л мартагдаад явах уу? Тэгэхээр энэ дээр бас боловсролын сайдаас бас өөрийнхөө дүгнэлтийг.

**Ч.Ундрэм:** Хязгаарлалттай дүгнэлтийн талаар Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Самбууням хариулах уу? 7 номерын микрофоныг өгье.

**Ц.Наранчимэг:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төрийн аудитын дээд байгууллага Төрийн аудитын тухай хуульд заасан буюу аудитын олон улсын стандарт аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу санхүүгийн тайланд аудит хийхдээ 4 дүгнэлтийг өгдөг. Өөрчлөлтгүй буюу эрсдэл багатай, хязгаарлалттай байх юм бол эрсдэлтэй асуудал байна аа. Сөрөг буюу татгалзсан Төрийн аудитын тухай хуульд сөрөг дүгнэлт авсан бол хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь өгнө. Татгалзсан дүгнэлт авбал ажлаас халах албан шаардлагыг өгдөг. Ийм одоо зохицуулалттай байгаа. Бид танд эхнээс нь яагаад хязгаарлалттай санал, дүгнэлт авсан асуудлууд энэ олон байгууллага дээр байгаад байна вэ гэхээр таны ярьсан олон жилийн насжилттай найдваргүй болох эрсдэлтэй авлагууд бас нэлээд их байгаад байгаа. Өглөг авлагынхаа тооцоо нийлдэггүй, санхүүгийн тайлангийн аудитын хамгийн гол асуудал санхүүгийн 4 тайлан дээр байгаа тоог бид баталгаажуулж Улсын Их Хурлын гишүүд болон олон нийт хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийг бодлого шийдвэр зөв гаргахад бид нарын баталгаажуулсан тоо зөв байх ёстой. Аудитын санхүүгийн тайлангийн хамгийн гол асуудал бол 4 тайлангийн тоог баталгаажуулах байгаа.

Тэгэхээр олон жилийн насжилттай найдваргүй авлага буюу өглөг авлагын тооцоо нийлэхгүй байна гэдэг маань тэр санхүүгийн тоон дээр одоо үнэн зөв байна гэх үүднээс эрсдэл байгаа учраас энийг одоо эрсдэлтэй гэж үзэж хязгаарлалттай дүгнэлтийн одоо гол үндэслэлийг болгож байгаа. Мөн Худалдан авах ажиллагааны тухай хуулийн зөрчлүүд байгаад байгаа. Худалдан авах ажиллагааны тухай

хуулийг мөрдөж ажиллахгүй байгаа нь нийцлийн асуудлын зөрчил болж ингэж ажиллаж байгаа. Их дээд сургуулиуд дээр сургалтын төлбөрийн тооцооны асуудал байна. Сургалтын төлбөрийг одоо үнэн зөв бодитой оруулж тооцоо нийлэх өглөг авлагаа зөв тусгах, зөв зарцуулах ийм асуудлууд байгаад байгаа учраас ийм үндэслэлээр бол бид яг стандартын дагуу хязгаарлалттай гэсэн ийм санал дүгнэлтийг өгч байгаа. Бид нар Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд өөрчлөлт ороод төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хүлээж аваад 30 хоногийн дотор төлөвлөгөө гаргаж ирүүлэх хуулийн шинэ зохицуулалт мөрдөгдөөд одоо 2023 оны 7 дугаар сараас эхэлж мөрдөгдсөн. 30 хоногийн дотор төлөвлөгөөгөө ирүүлээгүй бол хариуцлага тооцно. Энэ олон алдаануудаа ямар ажил хийж зохион байгуулж одоо засаж сайжруулах юм бэ гэдэг төлөвлөгөө гаргадаг болсон шинэ хуулийн маш чухал зохицуулалт болсон байгаа. Энэ төлөвлөгөөгөө ирүүлээд үүний дагуу нь одоо бид бас арга хэмжээ авна. Олон жил болсон найдваргүй болгож төсвийн мөнгийг найдваргүй болгож өргүй зарж байгаа энэ гол асуудал дээр бид нар энэ жилээс эхлээд.

**Ч.Ундрам:** Энэ дээр би нэг бас юм тодруулаад асуучихъя Наранчимэг даргаас. Яг энэ сөрөг татгалзсан дүгнэлт гарсан. Манай БСШУС-ын яг ямар ямар төрийн байгууллагууд байна. Яг тэр байгууллагууд байгаа бол нэрийг нь хэлээд өгдөө. 7 номерын микрофоныг өгчих.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Сөрөг дүгнэлт авсан газрууд Завхан аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар Улиастай хотын 4 дүгээр цэцэрлэг,

Цэцэг сумын сургууль гэсэн ийм 3 газар сөрөг дүгнэлт авсан байна. Соёлын сайдаас болохоор Говь-Алтай аймаг дахь орон нутгийн судлах музей сөрөг дүгнэлт авсан. Хязгаарлалттай дүгнэлтийг бол 82 байгууллага. Боловсрол шинжлэх ухааны сайдад 82 байгууллага, Соёлын сайдаас 17 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авсан. Олимп биеийн тамир спорт хорооноос 5 байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт авсан.

**Ч.Ундрам:** Баярлалаа. Батнайрамдал гишүүний асуултад Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ боловсролын зээлийн сангийн энэ асуудал бол олон нийтийн анхаарлын төвд ороод нэлээдгүй бас хугацаа болсон. Энийг ил тод цаашидаа энэ эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор бас бид бас томилгоо бид нар хийгээд явж байгаа. Одоо Сийлэгмаа гэж хүн зээлийн сангийн даргаар ажиллаж байна. Ер нь бол гадаад зээлийн авлагыг харах юм бол 1380 хүн төлөөгүй байгаа. Тэгээд энэ насжилтыг нь харахаар 10-аас дээш жил төлөөгүй нөхөд бол 502 хүн байна. Тэгээд тогтолцоог нь харахаар 1997-2012 он хүртэл бол энэ зээл аваад сурчихсан хүмүүсийг эргээж ирээд төрийн байгууллагад ажилласан тохиолдолд зээлээс нь ийм чөлөөлөх хөнгөлөх ийм систем явж байгаад 2012 оноос хойш энэ систем нь байхгүй болчихсон. Гэвчиг энэ хооронд тухайн үеийн сайд нарын одоо 5 удаагийн тушаалаар энэ бол одоо хууль зөрчиж чөлөөлсөн л гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудлыг бид нар цэгцэлнэ ээ цэгцэлнэ. Энэ зээлийн сан чинь эргэн төлөлттэй байж байж дараагийн хүндээ боломжийг олгож байгаа. Тэгээд ингээд тушаал гаргаад чөлөөлөөд яваад байж болохгүй. Бас энэ дотоодын зээлийн асуудал ч байгаа.

Энийг аймгийнх нь прокурорын газарт хандаад бид бас зээлийн эргэн төлөлтийг хийлгэхээр ажиллаж байна. Яг энэ гадаадаас энэ авсан энэ зээлийг буцаалгах энэ гадаадад сурч ингэж ирсэн энэ буцаалгах энэ асуудал дээр бол энэ тогтолцоогоо бас энд Байнгын хороотойгоо ярилцаж байгаад бид нар бас шинэчилье гэж бодож байна. Ер нь төрийн албанд чадварлаг албан хаагчдыг татъя гэвэл бас энэ системийг ашиглаж ирсэн туршилага бий. Буцааж төлөх энэ нарийвчилсан ийм бодлогыг бүхэлд нь шинэчлэх ийм шаардлагатай гэж харж байгаа. Энэ асуудлаар би бас Байнгын хороотойгоо ярилцаж байгаад Боловсролын зээлийн сан дээр шинэчлэл хийж эхэлнэ ээ. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Батнайрамдал гишүүн тодруулъя.

**О.Батнайрамдал:** Сая Наранбаяр сайд хэллээ л дээ. Яг таны хэлж байгаа яг зөв. Янз бүрийн системээр бид нар тушаал тогтоол гаргаад л явсан байгаа юм. Тэгээд яг 2012 оноос хойш маш олон сайд нарын чөлөөлөлтүүд явсан. Яг та хэлчихлээ. Бүгдээрээ хууль бус явсан. Тэгэхээр энэ чинь бүгдээрээ ард нь дандаа татвар төлөгчдийн мөнгө. Тэр битгий хэл хууль бус чөлөөлөгдөж байгаа бас тэр суралцагчдын буруу гэж хэлэхэд бас хэцүү байхгүй юу. Олноороо чөлөөлөгдөж байх тэр дунд нь ингээд нэр нь ороод явчихсан байх жишээний. Тэгэхээр энэ дундаас олон суралцаж би одоо зээл авч суралцсан хүмүүс бас ингээд хохироод үлдсэн энийг бас дурдах ёстой.

Тэгэхээр сая бас Боловсролын зээлийн сан дээр та сая хэллээ. Нэг шинэ томилгоо хийсэн байна лээ. Тэгэхээр энэ асуудал дээр өөрөө бас шүгэл үлээгээд асуудлыг гаргаж ирээд олон нийтэд бас тайлбарлаад явж байсан. Тэр

Сийлэгмаа дарга томилогдсонд бол бас хувьдаа баяртай байгаа юм. Тэгэхээр энэ 10, 20 жил бугширч явсан асуудлыг бүгдээрээ энэ дээр цэгцлээд цэг тавиад одоо дараагийн үе рүү орох хэрэгтэй.

Яагаад гэх юм бол бусад орны хөгжсөн орны бүх жишгийг аваад үзсэн ч гэсэн дандаа сайн залуучуудаа үнэхээр дэлхийн шилдэг боловсрол руу явуулаад шилдэг технологийг эзэмшүүлээд буцаж ирээд эргээд эх орныхоо хөгжилд одоо хувь нэмрээ оруулсан түүх маш олон давтагддаг. Тэгэхээр яг энэний суурийг тавьсан тэр татвар төлөгчдийн мөнгө бол өөрөө Боловсролын зээлийн сан байсан байгаа юм. Тэгэхээр Байнгын хороон дээрээс бас одоо Наранбаяр сайдтай бас хамтраад энэ дээр Ундрэм дарга бас зөвшөөрөх юм бол бид нар ажлын хэсэг бас байгуулах гэж байгаа. Энэ боловсролын зээлийн санг бүгдээрээ хамтраад шийдэл гаргаад цэглээд явъя аа. Тэгэхгүй бол ингээд цэглэсээр байгаад улс төрийн одоо сүүлдээ ингээд шийдэлгүй ингээд жил болгоны аудитын дүгнэлт дээр л нэг ингээд асуудал болоод л өнгөрөөд байх юм.

Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Боловсролын зээлийн сан Монгол Улсад хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гагцхүү тэр нь яг одоо тэр зорилгодоо нийцсэн одоо ард түмний хүүхдүүд дундаас хамгийн чадалтай хүүхдүүдийг нь сонгон шалгаруулаад шударгаар ил тод нээлттэй тэгээд тэр дэлхийн шилдэг сургуулиудад нь явуулж дараачийн үеийн мэргэжилтнүүдээ бэлдэхэд зориулагдах ёстой. Өмнөх үед бас яг энэ зорилгодоо хүрч явсан хүмүүс байгаа юу гэвэл байгаа зөндөө байгаа. Тэгэхээр бид нар энэ өмнөх үеийнхээ бас болохгүй бүтэхгүй байгаа юмнуудыг цэгцлээд бүх одоо энийг яаж шийдэх юм шийдлүүдийг нь шийдээд тэгээд урагшаагаа одоо шууд дүрэм журмаа

сайжруулаад явах ёстой гэж бодож байгаа.

Тийм ч учраас Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулаад тийм Батнайрамдал гишүүнийг бол энэ ажлын хэсгийг ахална гэж бодож байгаа. Тэгээд одоо намуудын бас бүлгээс хүмүүс оруулаад ингээд бид нар яамтайгаа хамтраад дүрэм журмаа цэгцлээд урагшаа явах ёстой. Тэгээд энэ дээр цаг алдахгүй намрын чуулганы үеэр ажиллана гэж төлөвлөж байгаа.

Дараагийн асуултыг Гонгорын Дамдинням гишүүн асууя.

**Г.Дамдинням:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн ярианаас нь эхлээд л явчихъя даа. Би ч гэсэн бас нэр холбогдоод л баахан гөвүүлээд л гүтгүүлж явж байгаад л дууссан. Ер нь бол энэ Боловсролын зээлийн сантай холбоотой асуудлыг энэ яам өөрөө тэр гэрээ хэлэлцээр юмнуудаа их тодорхой болгочихмоор юм байна лээ л дээ. Төлөх ч юм шиг, төлөхгүй ч юм шиг. Монгол Улсад ирээд 5 жил ажиллаарай тэгвэл чөлөөлнө гэсэн гэрээ хийж хүмүүст өгч явуулчихаад ирснийх нь дараа баахан улс төр хийгээд л тамласан шүү дээ. Төр амлалт өгсөн юм бол тэрийгээ биелүүлдэг байх ёстой байхгүй юу. Тэгээд мань мэтийн нэг улс төрч нөхдүүдээ барьж авч нүдээд л байсан, мөнгөө аваачаад төлчихсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлчихсэн бүх юмаа хийчихсэн байхад л ингээд л маш тодорхой бус гэрээ оруулж ирсэн. Гэрээ зохицуулалттай учраас л нэг ийм дэмий хэл ам болоод байсан байхгүй юу даа. Тэгэхээр үнэхээр тэр мөнгө төгрөгийг нь төлүүлэх гээд байгаа бол бүгдийг нь төлүүл. Тэр чөлөөлчихсэн байгаа хүмүүсийг нь бүгдийг нь шүүхэд өг. Тэр хууль, шалгадаг газруудад нь өгчих хэрэгтэй. Энэ дээрээ бас ахиж гаргаарай. Наранбаяр сайд аа. Хэлж байна шүү дээ. Би бол одоо хувьдаа

мөнгийг нь төлчихсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ явах ёстой сургуульдаа яваад төгсөх ёстой сургуулиа төгсөөд эргэж ирж мэдэгдээд төрдөө ажиллаад ингээд л явж байгаа байхгүй юу. Тэгээд одоо Улсын Их Хурлын гишүүн болохоороо л алуулж явсан л даа нэг хэсэг.

Тэгэхээр энийг хэдүүлээ нэг цэгцлээд тавьчихсан нь дээрээ ил болгоод хаячихсан нь дээр. Ер нь бол Монголын төр энийг бол хааж болохгүй. Боловсон хүчнээ бэлдэж авдаг байх ёстой ийм бодлого бол бүх улс оронд байдаг. Энийг хэрэгжүүлэх ёстой.

Хоёрдугаар асуудал энэ Биешин тамир спортын улсын хороо олимпын сайдтай болоод мандан бадраад давхисан чинь Олимпизмын түүхэндээ хамгийн муу амжилт гаргасан жил болчхов уу даа хэдүүлээ. Энэ шигшээ багууд дээрээ ер нь ямар хариуцлага тооцож байна? Татвар төлөгчдийн мөнгөөр түүхэнд байгаагүй хамгийн их зардал гаргасан дэмжлэгтэй л ийм жилүүд өнгөрсөн дөө. Тэгээд одоо энэний мөрөөр авч байгаа арга хэмжээнүүд ер нь юу байна? Энийгээ нэг хэлээч? Биешин тамир спортын улсын хороо.

Гуравдугаарт Соёлын яам, манай тойрог, Дархан-Уул аймагт музейн номын сангийн цогцолбор гээд одоо бүүр нэг Дарханыхаа залуучуудыг нэг ордог оюунаа мэдлэгээ энэ урлагийн боловсролоо сайжруулдаг нэг ийм сайхан юм хийчихье гээд бид нар төсөвт тавиад явуулж байгаа. Тэгээд их удаад байх юм аа. Юу болоод ингээд удаад байгаа юм. Энэний гүйцэтгэл ер нь яах юм. Энэ дээр нэг хариулт өгөөч.

**Ч.Ундрам:** Биешин тамир спортын улсын хорооны дарга Баттулга хариулъя. 1 дүгээр микрофон өгчих.

**О.Баттулга:** Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэндийг хүргэе.

Дамдинням гишүүний асуултад хариулъя. Биеийн тамир спортын улсын хороо, үндэсний шигшээ баг бүрдүүлэх энэ үйл ажиллагаанд зориулан 2024 онд бол 25.7 тэрбум төгрөгийг зарсан. Улсын төсвөөс тэгээд энэ дээр бол 26 төрлийн спортын төрөл шигшээ баг барьж байгаа. Олимпод оролцсон амжилтын талаар бол холбоодууд 2017 оны хуулиараа шигшээ багийг бүрдүүлэн зохион байгуулж бэлтгэл сургуулилтыг хангах үүргийг холбоо төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр, гэрээгээр гүйцэтгүүлэхээр тусгасан байгаа. Холбоодууддаа бид бол тайлангаа ирүүлэх шаардлагыг тавьчихсан байгаа. Тайлан ирэнгүүт бид нар дүгнэлтээ гаргана. Дүгнэлт гарч байж Засгийн газар дээр Олимпод бэлтгэх үндэсний хороон дээрээ бид нар тайлангаа тавиад тэгээд энэ хүрээндээ цаашаага ямар хариуцлагын шийдвэр гарах вэ гэдгээ ингээд танилцуулаад явна аа.

**Ч.Ундрэм:** Наранбаяр сайд, Боловсролын сайд. Боловсролын зээлийн сантай холбоотой асуултад хариулъя.

**П.Наранбаяр:** Дамдинням гишүүний энэ саналтай бол би 100 хувь санал нэгдэж байна. Ингээд Сангийн яамныхыг харсан ч гэсэн тэр тухайн үедээ энэ боловсролын зээлийн сангаар очоод суралцаад сурч мэдсэн зүйлээ төрд ажиллаж, яг тухайн үеийнхээ 2012 он хүртэлх одоо тэр журмынхаа дагуу 5 жил ажиллаад зээлээ тэглэж өөрийнхөө хувь нэмрийг оруулсан хүн зөндөө бий. Ингээд яг энэ зорилго нь яг юу юм бэ? Улс орондоо зөв ийм мэдлэг, ноу хау чадвартай хүнийг авч ашиглая гэсэн ийм л зорилго байгаа шүү дээ. Ирээдүй үеэ дэлхийг үзүүлж мэдлэг мэргэжилтэй болгоод тэрийг нь эх

орондоо ашиглая л гэсэн ийм зорилго байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ зорилгоос бол бид гажихгүй ээ цаашаа явна. Тэгээд буцаах бодлогыг нарийвчилъя гэдэг чинь энэ. Чөлөөлөх бодлогыг нь нарийвчилъя. Хэнд ч ойлгомжтой болгоё. Зээлээ авахад ч гэсэн хүнээс хамаарах хамаарлыг нь эрс бууруулъя багасгая гэдэг нь бидний бодлого.

Тийм учраас энэ бол Боловсролын зээлийн сан Монголд явж байгаа сангуудаас хамгийн амжилттай ажиллаж байгаа, хамгийн шударга, хамгийн ил тод, нээлттэй гэсэн ийм л зүйл рүү бид аваачна аа. Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөртлөн ирдэг. Энэ одоо Боловсролын зээлийн сангаар ингэж ийм одоо эрдмийг өвөртөлж ирсэн хүмүүсийг бид үгүйсгэх бодлого огт барихгүй ээ. Энийг бол хариуцлагатай хэлье. Дүрэм журмаа барина. Зарим нэгэн одоо нетээр яваад байгаа тэртээ тэргүй журамдаа өөрөө яг ингээд тэнцээгүй хүмүүсийн эд нар ярилцлагууд нэлээн явж байна лээ. Бид ийм юм дээр хатуу зогсоно. Яг л дүрэм журмыг нь баримталбал. Буцаалт дээр ч гэсэн хариуцлага нэхнэ. Мөн одоо үр дүнг нэхнэ. Ийм бодлого барина. Тантай бол санал нэг байна.

**Ч.Ундрэм:** Соёлын яамтай холбоотой асуултад Даваажаргал дарга хариулъя. 8 номерын микрофон.

**А.Даваажаргал:** Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Дархан-Уул аймгийн мужийн номын сангийн цогцолбор барилга, 2024 оны улсын төсөв дээр суугдсан Воком констракшин компанитай 4.9 тэрбум төгрөгийн гэрээ хийгдсэн. Барилгын ашиглалтад орох хугацаа бол гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон. Аймгийн ЗДТГ-аас гэрээний хугацааг 2

удаа сунгасан байгаа. Яг одоо өнөөдрийн байдлаар бол Барилга угсралтын явц 100 хувьтай гадна болон дотор өрлөгийн ажил 100 хувьтай, дотор заслын ажил 20 хувьтай, дотор цахилгааны ажил огт хийгдээгүй, дотор агаар сэлгэлтийн ажил 20 хувьтай, гадна дэд бүтцийн ажил 10 хувьтай явж байгаа. Яг одоо үүсээд байгаа хүндрэлтэй асуудал юу байгаа вэ гэхээр анхны зураг төслийг батлахдаа дотор интерьерийн зургийг огт оруулаагүйгээр зураг төслийг баталсан. Тэгээд интерьерийн зургийн ажлыг бид нар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүсэлт тавиад 200 сая төгрөг шийдвэрлэгдсэн. Үүний дагуу интерьерийн зураг буюу дотор дэглэлтийн ажлын зургийг бол боловсруулж байгаа. 2025 оны төсөв дээр 1.4 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлээд ингээд ажиллаж байгаа. Ер нь бол энэ төсөв батлагдах юм бол 2025 ондоо багтаагаад энэ ажлыг дуусгах ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна аа.

**Ч.Ундрам:** Гонгорын Дамдинням гишүүн тодруулъя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр би яг зөв би яг наадхыг чинь хэлүүлж байгаад хэлье гэж бодож байсан. Соёлын яамныхан та нар одоо ингээд яам байгуулагдаад ингээд ажиллаад ингээд төлөвлөлт хийхдээ энэ музей, номын сан, энэ тусгай барилга байгууламжийн стандартыг бодож зураг төсвөө хийлгэхгүй бол 2, 3 давхар ажил болчихоод байгаа байхгүй юу. Барилга нь баригдчихдаг дотор нь тусгай зориулалтын стандарт зайлиггүй байх ёстой гээд дахиад баахан мөнгө гараад ингээд хугацаа нь хойшлоод яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр та нар энийгээ энэ төсөвлөлт хийхдээ анхнаасаа энэ төлөвлөлтөө гаргахдаа тэр чинь зүгээр жирийн нэг барилга биш ээ. Дотор нь тэр агааржуулалт

чийгшүүлэлт хадгалалт хамгаалалт гээд баахан юмнууд байдаг юм байна лээ. Энэ стандарт нормоо шинэчилж та нар энэ даалгавраа зургийн даалгавар юмнуудаа сайн өгөөч ээ. Энэ дээрээ бас анхаармаар байгаа юм аа. Тэр Биеийн тамир спортын улсын хороо өнгөрсөн хавар одоо бид нар сонгуулийн өмнө Биеийн тамир спортын тухай хуулийг шинэчилж баталж өгсөн. Холбоодод хариуцлагаа шилжүүлэх эрх нь та нар байгаад байгаа мөртөөсөө холбоодуудад хариуцлагаасаа бултаж одоо холбоодууд мэддэг юм аа гээд ингээд бултаад байдаг байсан байдлыг чинь одоо болиулж байгаа шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжүүлж байгаа байхгүй юу. Татвар төлөгчдийн мөнгөөр л бүгдийг нь дамжуулж хийлгэж байгаа холбоодоор. Холбоод хариуцлагаа бүтэн хүлээдэггүй. Тамирчид нь ёс зүй сахилга хариуцлагаа барьдаггүй. Ийм байдлыг нь болиулаад өгөөч ээ л гэж бид нар яриад байгаа шүү дээ. Насаар нь цалин авдаг хүмүүс байна. Нөгөөдүүл нь гадуур бөөн дуулиан шуугиан тариад л нийгэмд буруу үлгэр дуурайлал үзүүлээд байна.

Тэгэхээр энэ хүмүүсээ хариуцлагажуулах тал дээр нь анхаарч энэ улсын төсвийн мөнгөний зарлагыг хариуцлагатай болгооч л гэдэг юмыг ярьж байгаа шүү. Тэгээд хэдүүлээ бас энийг дахиад ярилцана аа.

**Ч.Ундрам:** Тийм Баттулга дарга хариулахаас өмнө ер нь энэ саяын одоо олимптой холбоотой асуудалд Монголчууд Монголын ард түмэн бол үнэхээр сэтгэл гонсгор байгаа. Бид нар тэгээд энэ үр дүнгээ хараад алдаа бол байгааг бүгдээрээ ухамсарлах ёстой. Цаашид энэ алдаагаа яаж засах вэ, хаана яг алдаа гарав гэдгээ бүгдээрээ нэг дүгнээд тэгээд алдаагаа засаад урагшаа явах ёстой. Тэгээд энэ дээр бас Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж

ажиллана гэж бодож байгаа. Тэгээд байнгын хорооны одоо Дамдинням гишүүн бол бас эмэгтэйчүүдийн сагсны спортыг дэмжээд олон улсад амжилт гаргаад явж байгаа бас ийм туршилагатай гишүүн учраас Дамдинням гишүүнээр ахлуулъя гэж ер нь бодож байгаа. Тэгээд энийг намрын чуулганаар эд нар бол бүүр нухацтай одоо паралимпын дараа бүгдийг нь дүгнээд нухацтай хэдүүлээ ярилцана шүү гэдгийг хэлмээр байна аа. 1 номерын микрофоныг өгье.

**О.Баттулга:** Дамдинням гишүүнтэй санал нэг байгаа. Спортын холбоотойгоо бид нар хариуцлагын асуудлыг ярина аа. Энэ дээр нэг асуудал байгаа юм. Бид нар нөгөө 25.7 тэрбумыг 2024 ондоо зарж байгаа юм. Энэ нь задаргаагаараа бол бол тэмцээн уралдаанд 12.5, баг тамирчдын цалинд 5.6 гадаад дотоодын бэлтгэл 4.2 гээд ингээд задаргаа тодорхой тоог нь би бас та бүхэнд хүргүүлье ээ. Тэгээд хамгийн гол нь шигшээ багийн бүрэлдэхүүнд байж байгаа багш дасгалжуулагчдын цаашдын нөгөө бэлтгэл сургуулилтын дасгалжуулалтын түвшнийг хэрхэн одоо яаж сургуулилтыг авч явах вэ гэдэг энэ дээр бол бид нар нарийн одоо төлөвлөгөө судалгаа гаргана аа. Энэ олимпод гаргаж байгаа энэ амжилтынхаа дараагаар бид нар өчигдрөөс авхуулаад энэ төрийн бус байгууллагууд дээр бас хэлэлцүүлэг явж байгаа. Тэгээд саналуудыг авч байгаа. Тэгээд өөрсдийн түвшиндээ ч гэсэн одоо паралимпна дуусахаар зэрэг энэ дээрээ нэгдсэн дүгнэлтээ гаргаад тэгээд хаанаа алдаа гаргасан, аль алдаагаа бид нар яаж засах вэ гэдгээ ингээд түвшин түвшиндээ ярилцаад явцгаана аа. Тэгээд та бүгдийн саналыг дэмжиж байна аа.

**Ч.Ундрам:** Бадрахын найдлаа гишүүн асуулт асууя.

**Б.Найдалаа:** Баярлалаа. Түрүүн Боловсролын зээлийн сантай холбоотой асуудал байлаа. Тэгээд асуудал ерөнхийдөө асуулт давхацсан учраас товчлоод асууя. Нийт 120 тэрбум төгрөгийн авлага үүсчхээд байгаа юм. Тэгээд энийг бол одоо ингээд шуугилдаад бараг 4, 5, 10-аад жил болж байна. Нэг тийш нь цэгцэлмээр байгаа юм. Авахыг нь аваад авахгүйг нь авахгүй. Улс төрийн болон албан тушаалын хариуцлага хүлээх юм бол хүлээгээд хүлээхгүй бол хүлээхгүй, хөнгөлбөл хөнгөлөөд төрийн байгууллага болохоор л ингэж явж байгаа болохоос банк санхүүгийн чинь бусад өр ширний асуудлууд аль хэдийн нэг тийшээ болчихсон. Хөнгөлөхийг нь хөнгөлөөд хаахыг нь хаагаад дуусгамаар байгаа юм. Энэ дээр Боловсролын яам маань анхаарах байх.

Хоёрт ер нь зүгээр энэ Боловсролын зээлийн сангийн талаар гадаадад залуусаа сургах талаар бодлогын маш том алдаа байгаа гэж би боддог. Ийм алдаатай байгаа болохоор Боловсролын зээлийн сан ийм дампууралд хүрч байгаа юм. Ийм байгаа болохоор зарим хүн төлөхгүй байгаа юм. 120 тэрбум төгрөг төлөхгүйгээр олон 10 жил ингээд маргаад ч юм уу яагаад ч юм ингээд яваад байна гэж байгаа бол угаасаа сууриараа бодлогын алдаатай гэсэн үг юм аа. Тэгээд энийг залруулах хэрэгтэй байгаа. Энэ дээр тодорхой саналууд санаа байгаа. Би зүгээр энэнээс өмнө дараа хэлье. Энэнээс өмнө Боловсролын яамнаас асуумаар байгаа юм. Яг энэ дээр Боловсролын зээлийн сан буюу цаашидаа гадаадад сургах эрдэм мэдлэгийг авчрах энэ дээр ямар бодлого баримталж байгаа вэ? Яг одоо бол одоогийн манай үйлчилж байгаа энэ бодлого бол Боловсролын зээлийн сан гадаадад оюутнаа сургах бодлого бол эрдэм мэдлэгийг авчрах биш зүгээр эрх мэдэлтэй, мэдээлэлтэй тэгсэн хэрнээ гадаадын тэтгэлэгт тэнцэж чадахгүй



ийм хүмүүст зувчуулах зорилготой гадаадад явуулах бодлого болчихоод байгаа юм аа.

Тэгээд энийг яаж залруулах юм бэ, ямар бодлого байгаа юм? Энийг жоохон тодорхой саналаа хэлээч.

**Ч.Ундрэм:** Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ ер нь бол өнөөдөр нэг хугацаа хэтэрчихсэн ийм авлагын насжилттай энэ авлага нь ингээд харахаар энэ 120 орчим тэрбум, ер нь нийт авлага нь бол 209 тэрбум байж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр энэ одоо чанаргүй болсон гэх юм уу авлагын энэ асуудал дээр АТГ-т хандчихсан бол бүх материал нь АТГ дээр очоод шалгагдаад АТГ гэсэн үг. Бараг 20 сар болж байна. Тэгэхээр бодлогын хувьд бол маш тодорхой байх хэрэгтэй. Ер нь төрийн албанд зүтгээд ингээд ажиллачхаж байгаа ийм хүмүүсээ чөлөөлдөг бодлогыг бол эргэж сэргээж оруулж ирэх шаардлагатай. Тэгээд хасалтыг нь хийх хэрэгтэй. Энэ чинь дэлхийн нэртэй сургууль төгсчөөд төрийн албандаа ажиллаж байна гэдэг чинь энэ том хөрөнгө оруулалт байхгүй юу. Тэгээд 2 дугаарт нь болохоороо зэрэг бид бас энэ үнэхээрийн зээлийн гэрээгээ зөрчөөд алга болчихсон хүмүүстэй бол эрүүгийн хариуцлага хүртэл ярьж ингэж тооцох ёстой. Энийгээ ялгаж салгаж ингэх ажил ид явагдаж байна. Тэгээд энэ Байнгын хороон дээр бас энэ ажлын хэсэг байгуулагдаж байгаад би Боловсролын сайдын хувьд маш талархалтай байна.

Тэгээд хамтраад энэ ажлаа үргэлжлүүлээд энийгээ маш тодорхой болгоод ингээд олон нийтэд зарлаад явна аа. Түрүүн миний хэлсэн ил тод байхын зарчим, түрүүнд миний хэлсэн ийм шударга байх зарчим энэ бүхэн энэ

зээлийн сан дээр үйлчлээд явах учиртай гэж бодож байна. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Найдалаа гишүүн тодруулах уу? Болсон уу? Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Энэ өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа асуудал бол уг нь өнгөрсөн хавар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдээд явчих байсан асуудал. Тэгээд одоо сонгууль гэдэг шалтгаанаар хойшлуулаад ерөөсөө хэлэлцэлгүй өнгөрчих хэмжээнд оччихоод байсан байхгүй юу. Тэгээд Ёс зүй дэгийн байнгын хорооноос хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачилж байгаад одоо энэ 9 сарын 1-ээс өмнө ингээд хэлэлцээд явж байгаа юм. Энэ чухал асуудлыг ингээд хаячихсан явдал бол Улсын Их Хурлын гишүүд өөрснөө хуулиа зөрчиж Улсын Их Хурал хуулиа зөрчөөд ингээд явчихсан байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн нэмэлтийг нэг удаа хэрэглэх байдлаар оруулъя гэж би санал гаргасан боловчиг хууль эцэслэн батлагдахдаа тэгээгүй.

Тийм учраас энийг Байнгын хорооны протоколд тусгаад энэ 6 сард хаврын чуулганаар хэлэлцдэг асуудлыг зөвхөн энэ удаа л ингэж хойшлуулж хэлэлцье. Бусад үед хугацаанд нь дэгийн хуулиараа хэлэлцдэг байя гэдэг саналыг бол дээш нь тавимаар байгаа. Тавьж байгаа юм. 2 дахь асуулт бол энэ аудиттай холбоотой юм аа. Тэгэхээр манайд бол аудитын миний ажиллаж байсан байгууллагад аудит бол байнга л ажилладаг. Ноднин энэ 2023 онд бол одоо үндсэндээ гүйцэтгэл нийцлийн аудит хийгдсэн. Тэрэн дээр бол энэ аудитын байгууллага шинжлэх ухааны байгууллага бол их хамтарч ажиллах боломжтой юм байна. Хэн хэндээ санаа оноо өгч болдог юм байна гэдгийг одоо харсан.

Зүгээр санхүүгийн аудит дээр бол асуудал гарч байгаа юм. Зарим компаниуд байгууллага дээр ирчхээд заавал хангалтгүй гэсэн үнэлгээ өгөх гээд гүрийгээд байдаг ийм юм байдаг аа. Энэ асуудал дээр та бүхэн маань тэр компани сонгож шалгаруулж явуулахдаа бас сайн анхаарч байгаарай. Одоо ингээд аудит бидэнд зөвлөмж өгнө. Зөвлөмжийг бол бид нар ер нь бараг л 100 хувь биелүүлэхгүй бол хэцүү л дээ. Аудитаас бол их шаардана. Гэтэл Засгийн газарт энэ асуудлаа өгсөн 2022 оны энэ асуудалд өгсөн зөвлөмжийн гүйцэтгэл 60 хувь гээд байгаа юм. Тэгэхээр энэ гүйцэтгэлийг энэ биелэгдээгүй тохиолдолд аудит яадаг юм бэ? Ямар арга хэмжээ авдаг юм? Ямар хуулийн боломж байдаг юм гэдгээ нэг хэлж өгнө үү гэсэн нэг асуулт байна.

Хоёрдугаар асуулт бол энэ хөрөнгө оруулалттай холбоотой байгаа юм аа. Одоо энэ онд хэрэгжих 883 төсөл арга хэмжээний хэрэгжилт 62.5 хувь гээд байгаа юм. Хамгийн олон төсөл арга хэмжээтэй нь манай боловсролын яам. Тэгээд энэ одоо юундаа байдаг юм энэ хэрэгжилтэд. Тэгээд одоо сая манай Байнгын хороо явж байхад барилгын компани хэлж байгаа юм. Ингээд барилгынхаа ажлыг хийгээд одоо гүйцэтгэлийнхээ материалыг бүрдүүлж өгөөд эргэн төлөлтөө авахад 60 хоног шаардагдаад байна гэж байгаа юм. Манай барилгын сезоны бараг 50 хувь, гүйцэтгэл гаргаснаас хойш 60 хонож байж мөнгөө авна гэдэг энэ асуудал одоо ямар хуулиар яаж зохицуулагдаад ийм нөхцөл үүсээд байдаг юм бэ?

**Ч.Ундрам:** Дэгийн хуультай холбоотой асуудлаар Рэгдэл гишүүн та бас нөгөө Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд дахиж энд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн барьж болно шүү. Өнөөдөр тэгэхдээ протокол тусчихлаа. Энэ тэгэхдээ зөвхөн Байнгын хорооны протокол

учраас өшөө дараагийн шатанд аваачъя гэвэл та бас хуулийн төсөл өргөн барьж болно.

Аудиттай холбоотой асуудлаар Санхүү-нийцлийн аудитын газрын захирал Наранчимэг, 7 номерын микрофон хариулъя.

**Ц.Наранчимэг:** Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Үндэсний Аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын байгууллага улсын хэмжээний нийт 7122 төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитад төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд аудит хийж 6 сарын 10-ны дотор Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Улсын Их Хуралд хүргүүлж хэлэлцүүлдэг ийм Төсвийн тухай хуулийн заалттай. Тэгэхээр бид өнөөдөр ажиллаж байгаа хүний нөөцийн маань хүрэлцээ энэ санхүүгийн тайлангийн аудит хийж хүрэлцэхгүй байгаа учраас аудитын хуулийн этгээдийг Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр хийж гүйцэтгүүлдэг.

Нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар зохион байгуулдаг. Таны хэлж байгаа асуудал бол яг байгаа. Өнөөдөр Монгол Улсад аудитын хуулийн этгээдүүд маань бүгд одоо чадамжийн хувьд ч, мэдлэг чадварын хувьд ч, ур чадварын хувьд ч, хүний нөөцийн хувьд ч бүрэн боломжтой байна уу гэдэг асуудал бол бас анхаарч байгаа.

Тийм учраас бид нар жил болгон Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журмын дагуу ажлыг нь дүгнээд шаардлага хангаагүй аудитын хуулийн этгээдүүдтэй гэрээгээ одоо

цуцлаад явдаг ийм зохицуулалттай байгаа. Төрийн аудитын тухай хуульд заасан аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцох албан шаардлага өгдөг. Төлбөр төлөх боломжтой албан шаардлага дээр төлбөрийн акт тогтоох ийм хуулийн зохицуулалттай байгаа. Түрүүн хэлсэн Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт ороод аудитаас өгсөн энэ асуудлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө ирүүлнэ. Мөн төлөвлөгөөний дагуу хэрэгжилт хангалтгүй байвал бас хариуцлага тооцдог ийм хуулийн зохицуулалттай болж энэ жилээс эхэлж энэ нь мөрдөгдөж байгаа учраас төсөв захирагч нарт бас нэлээд энэ аудитаас өгч байгаа зөвлөмж албан шаардлагыг хэрэгжүүлэх энэ асуудал чухал болж байгаа.

Хоёрдугаарт нь аудитын байгууллага өөрсдөө бас энэ дээр анхаарч байгаа. Хэрэгжих боломжтой өгч байгаа зөвлөмж маань яаж хэрэгжүүлэх арга замыг нь зааж өгөх ийм зөвлөмжийг өгөхөөр бид бас ажиллаж байна. Албан шаардлагаар мөн одоо олон жилийн насжилттай, тухайн жилдээ хэрэгжүүлэх боломжгүй ийм авлага, өглөг дээр бид нар хувь заасан албан шаардлага өгч байгаа. Энэ ондоо та нар 20 хувийг нь заавал бараг дуулаарай.

Дараагийн боломжгүйг нь цаашилаад ингээд өгөөд явахаар ийм зохицуулалттай ажиллаж байна.

**Ч.Ундрам:** Энэ аудиттай холбоотой бас Наранчимэг дарга ингээд би ч өөрөө бас МУИС-ийн санхүү хариуцсан захирал хийж байсан. Тэгээд аудит ирдэг. Зарим юм нь бол үнэхээр тухайн байгууллагаас хамаарахгүй тэр төрийн дээд зохицуулалтаас хамаараад

бид нар тэгээд хязгаарлалттай дүгнэлт авчих гээд байдаг байхгүй юу. Тэгэхээр юун төлөө та нар чинь яг одоо Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа том байгууллага байна лээ. Бас зохих шатын Их Хуралд нь ч юм уу Засгийн газарт нь боловсролын хууль дээр ийм өөрчлөлт хийхгүй бол энэ доодох байгууллагууд чинь ингээд болохгүй байна ч гэдэг юм уу тийм зөвлөмжийг бас харж байгаад ингээд хүргүүлж баймаар юм байна лээ шүү. Тэгэхгүй бол яг нөгөө тухайн байгууллагыг хариуцаж удирдаж ажиллаж байгаа хүмүүс өөрөөсөө шалтгаалахгүйгээр хариуцлагатай дүгнэлт аваад тэгээд тэр нь дараа дараагийн бас янз бүрийн асуудалд орчих гээд байдаг зүйл байдаг.

Рэгдэл гишүүний дараагийн асуултад нь Сангийн яамнаас Санжаасүрэн дарга хариулах уу? 4 номерын микрофон.

Цогбадрах дарга Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга хариулна. 3 номер.

**Цогбадрах:** Тэрийг одоо дүгнэлтийг хэр авч байгаа юм гэж энэ дээр л хэлнэ шүү дээ. Гишүүний асуултад хариулъя аа. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах. 23 онд Боловсрол шинжлэх ухааны сайд дээр 399 төсөл арга хэмжээ хэрэгжсэн. Үүнээс 529.3 тэрбум төгрөг батлагдсанаас 516.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу хувилбал 98 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна Улсын төсвөөс. Гадаадын зээл тусламжаар бол 10 төсөл арга хэмжээ хэрэгжсэн. Тэгээд 67.9 тэрбум төгрөг батлагдаж 64.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй 94 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Ч.Ундрам:** Энэ гол асуудал асуугаад байгаа юм нь барилгын компани ажил гүйцэтгээд тэгээд

материал бүрдүүлж өгөөд дараагийн санхүүжилтээ авах гэсээр байтал 60 хоног болоод байна. Манайх чинь байшин барилга барих боломжтой хугацаа чинь маш богино байдаг. Тэгээд яагаад ингээд цаг алдаад байдаг юм бэ? Жишээлбэл энэ шинжлэх компанийн академийн одоо барилга байшин баригдаж байгаа энэ асуултыг асуугаад байна л даа Цогбадрах дарга аа.

**Б.Цогбадрах:** Ер нь бол хөрөнгө оруулалтын болон бусад урсгал зардлын ч бай санхүүжилтийг бол Сангийн яамнаас тодорхой одоо хууль тогтоомжид нийцсэн баримтыг үндэслэн олгодог. Хэрвээ баримт материал нь бүрэн байхад бол Сангийн яаман дээр тэр 60 хоног болох тийм шаардлага байхгүй. Бид нар бол хөрөнгө оруулалтын бас тодорхой систем дээрээ бас хөрөнгө оруулалтын санхүүжилтийг анх хүлээж авсан. Дараа нь хэн хянаж байна. Дараа нь аль газар хэлтэс рүү шилжлээ гэх мэтчилэн манай хөрөнгө оруулалтын систем дээр бол яг санхүүжилт нь хаана явж байгаа нь харагдаад байж байдаг тул тухайн одоо гүйцэтгэгч компаниуд материалаа л бүрэн өгсөн бол шаардлагаа л хангаж байгаа бол Сангийн яаман дээр 60 хонох ямар ч шаардлага байхгүй. Угаасаа ч санхүүжилт нь тэгж саатсан санхүүжилтүүд бол байхгүй.

**Ч.Ундрэм:** Рэгдэл гишүүн тодруулъя.

**Д.Рэгдэл:** Тэгэхээр энэ асуулт болбол Сангийн яам саатуулаад байна гэсэн агуулга байхгүй. Ер нь энэ бүх процесс нь яваад компани гүйцэтгэлээ гаргаад өгчихлөө. Одоо Барилгын хөгжлийн төв дээр ч очдог юм уу мэдэхгүй хаана очдог юм. Ингэж явсаар байгаад Сангийн яаман дээрээс санхүүжилт гартал 60 хоноод байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн шуурхай болгох ийм боломж юу

байдаг юм бэ? Үнэхээр 60 хоноод байдаг юм уу, үгүй юу. Дээд тал нь 60 хонож байна гэсэн л санаа байсан байх. Тэгэхдээ 60 хононо гэдэг бол угаасаа утгагүй л байгаа юм л даа. Тийм л юм асуусан юм.

**Ч.Ундрэм:** 60 биш ч байсан, 30 хоног ч байсан энэ бол хайран цаг хугацаа. Тэгэхээр энд хаа нэг газар ийм саатал үүсээд төрийн хүнд суртал гараад байна л даа тэгээд энэнд хариулмаар байна. Сангийн яамны Санжаасүрэн дарга 4 номер.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Рэгдэл гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтын асуудлыг бол Сангийн яамнаас аль болох нээлттэй иргэдийн мэдэх эрхийг хангах мөн энийгээ бол хяналтыг иргэдтэйгээ хамт хийх зорилгоор бол Цахим систем нэвтрүүлээд байгаа. Энэ цахим систем бол төсвийн төслийг одоо боловсруулж саналаа өгөхөөс өгсүүлээд гүйцэтгэлийг нь бүгдийг нь оруулаад дээр нь энийг улсын комисс хүлээж авахад нь хүртэл ямар хүмүүс яаж хүлээж авч байгаа вэ гэдгийг хүртэл нээлттэй бид нар бол оруулаад байгаа. Энийг бол бид нар Засгийн газрын тогтоолоор бол уул нь журамлачхаад байгаа юм. Сангийн яаман дээр бол тухайн төслийн хөрөнгө оруулалтын хүсэлт ирээд манай Хөрөнгө оруулалтын газар бол 3 хоногийн дотор хянаад Төрийн сангийн дунд газар бол 2 хоногийн дотор хянаад ингээд ажлын 5 хоногоос удах ёсгүй. Энэ бол цахим систем дээр [finance.gov.mn](http://finance.gov.mn) гээд хаягаар мөн гар утасны аппликэйшинээр бол харагдаж байгаа. Сангийн яаман дээр хэрвээ энэ хугацаанаасаа удаж байх юм бол энэ бол манай яаман дээр бид бол дотроо энийгээ байнга хяналттай явж байдаг энэнээс удаахгүйгээр шийдэж байдаг. Салбар яамдууд дээр бол нөгөө талдаа

ийм одоо зүйлүүд бол ирсээр гардаг. Бид нар бол Төсвийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийнх нь дагуу бас мөн салбар яамдуудад бол энийг шахах байдлаар хяналт тавих байдлаар ингээд явдаг. Хамгийн гол үзэж байгаа асуудал бол хаана байдаг вэ гэхлээр материал салбар яаман дээр ирдэг. Сангийн яам руу энийг хүргүүлэх хугацаа байдаг. Өөрөөр хэлбэл материал хангалттай хэмжээнд ирж байна уу үгүй юү гэдэг бол бас асуудал байдаг. Сангийн яамны хувьд ч тэр салбар яамны хувьд ч тэр захиалагчийн хяналтаа бол тухайн одоо юу гэдэг юм алслагдсан газар бол таны хэлж байгаагаар шинжлэх ухааны хүрээлэн бол гайгүй байх. Гэтэл алслагдсан одоо бүс нутагт байгааг бол хянахад байнга очоод хянаад байж чадахгүй учраас материалын бүрдэл дээр бол итгээж одоо санхүүжилтийг явуулдаг.

Тэгэхээр хаа хаанаа бас гарын үсэг маань өөрөө хариуцлагын асуудал байдаг учраас тэрэн дээр бол хариуцлагатай хандахыг хичээдэг байх. Нөгөө талдаа бол энийг бас хурдлуулах нь зүйтэй гэдэг дээр санал нэг байна аа. Цаашидаа анхаарч байя.

**Ч.Ундрам:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Найдалаа гишүүнээр тасаллаа. Галбадрах гишүүнээр тасаллаа. Найдалаа гишүүн үг хэлье.

**Б.Найдалаа:** Баярлалаа. Тэгээд түрүүнийхээ асуултынхаа дагуу би нэг санал хэлье. Энд яамныхан байх шиг байна Байнгын хорооныхон байна. Ямар ч байсан энэ Боловсролын зээлийн сан буюу гадаадад боловсон хүчин бэлдэх

энэ бодлогыг ул сууриар нь өөрчилмөөр байна. Энэ бодлого буруу болохоор бид нар асуудалд орчхож байгаа юм. нэгдүгээрт залуусаа бакалаврт ингээд л өндөр үнэтэй сургуульд хөлөө хугалан хугалан ингэж явуулах хэрэг байгаа юм уу. Энэ том суурь асуудал байна. Минийхээр бол шаардлагагүй гэж бодож байна. Аль болох бага шаардлага байгаа.

Хоёрт нь цөөн хэдэн од хүүхдийг од сургуульд явуулж нийтээрээ ингэж баясах хэрэг байгаа юм уу? Энэ бол сайн хэрэг. Гэхдээ нийтээрээ яг мэдлэгийг эх орондоо авчрахын тулд цөөхөн хэдэн хүүхэд дээр тулгуурлаж ингэж явах нь нийтэд тустай биш гэж бодож байна.

Гуравт нь гадаад улсын тэтгэлгүүд олон байдаг. Монгол Улс шиг ийм жижижхэн улсууд бол харьцангуй бүүр сайн гэж хэлж болно. Энийг дахиад яриа хэлцэл бодлогын түвшинд ахиулж болно. Ийм байхад бид нар асар их үнэтэй олон 100 тэрбум төгрөг зарцуулаад ингэж төвлөрөх нь зөв үү буруу юу гэдгийг бас бодох ёстой болж таарч байгаа юм.

Дараа нь бас хамгийн чухал нь ер нь гадаадад сургаж л байвал өндөр нөгөө рейтинг өндөртэй сургуульд сурч л байвал сайн, гадаад л явбал сайн гэдэг тэр үзэл баримтлалыг одоо тэр хандлагыг болих хэрэгтэй байна аа. Ерээд онд тийм байсан одоо бол биш шүү. Ялангуяа энэ 21 дүгээр зуунд биш. Тийм болохоор хамаг хөрөнгөө авлигатай нь нийлүүлээд, арын хаалгатай нь нийлүүлээд ингэж зарцуулах уу эсвэл Монгол Улсад дотоодын их дээд сургууль судалгааны сургуулиудаа яагаад бид нар бэхжүүлэхэд хөрөнгө хаяхгүй байгаа юм бэ? Энэндээ олигтой хөрөнгө хаяхгүй байж байж гадагшаага асар үнэтэй их хөрөнгө оруулдаг тэгээд энийг бол зарчмын хувьд сайн бодох ёстой.

Монголд яагаад дэлхийн түвшний топ түвшинд нь орох энэ сургууль байгуулах ийм зорилго байхгүй байгаа юм. МУИС эсвэл бусад их дээд сургуулиа ийм болгох бодлого байхгүй байгаад байгаа юм бэ? Хөрөнгө оруулалтаа гадагшаа цацаад байна тэр нь нийтэд биш цөөхөн хүүхдэд, цөөхөн хүнд магадгүй эрх мэдэлтэй мэдээлэлд ойр хүмүүст зарцуулагдчихаад байна аа. Энийг онцгой анхаарч байгаад хөрөнгө оруулалтаа анхаарлаа Монголд, Монголын их дээд сургууль хангалттай бакалаврын түвшинд сурахуйцаар тэрэнд сурч байгаа шилдэг хүүхдүүддээ өөрсдөө хангалттай тэтгэлгийг нь өгөхүйцээр бүүр хангалттай тэтгэлгийг нь өгөхүйцээр тэнд нь шилдгүүд нь боловсруулж тэнд нь шилдгүүд нь яг Монгол суурин дээрээ бакалаврынхаа түвшний мэдлэг авдаг ийм бодлого хэрэгтэй байна аа. Тэгээд энэ сургуульд орохын тулд гадаадад цөөхөн хүүхдийг явуулахын тулд биш яг нийт Монгол хүүхдийн дунджаар сайн боловсрол авах тэр чиглэл рүү нь хөрөнгө оруулалтаа чиглүүлэх хэрэгтэй.

Тийм болохоор Боловсролын зээлийн сангийн бодлогыг өмнөх 20, 30 жил явж ирсэн зарим хүмүүст гадаад явах боломж олгодог биш, нийт Монгол хүүхдүүдэд сайн боловсрол эх орондоо авах тэр чиглэл рүү нь хөгжүүлэх ёстой гэж бодож байна. Гадаад явах боломжууд байлгүй яах вэ. Тэрийг нь аль болох өөрийнхөө биш гаднын бодлогоор гаднын тэтгэлэг хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх байдлаар шийдвэл зөв өө гэж бодож байна аа. Тэгээд энэ дээр бол цаашидаа Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдах байх. Мааш анхаарч ажиллах ёстой гэж бодож байна. Энэ бол зөвхөн нэг хэдэн хүүхдийг гадаадад сургах тухай Боловсролын зээлийн сангаас зээл олгох тухай асуудал биш Монголын боловсрол ямархуу байх вэ гэдэг хандлагыг шинэ хандлагыг

тодорхойлох маш чухал зүйл юм шүү. Баярлалаа.

**Ч.Ундрам:** Энэ боловсролын зээлийн сангийн асуудал бол одоо маш чухал. Нэлээн одоо нийгмийн бас анхааралд орсон цаашид бид нар бас яг шинэ бодлогоо тодорхойлоод явах ийм эгзэгтэй үед байна гэж бодож байгаа. Тэгээд ихэнх бакалаврын мэргэжлийг бол Монголдоо бэлддэг болчихсон. Тэгэхээр бэлдэж чадахгүй байгаа одоо юу гэдэг юм соёлын өвийг сэргээн засварлах чиглэлийн ч байдаг юм уу, нано технологи, мехатроник ч байдаг юм уу ийм чиглэлийн Монголд бэлдэж чадахгүй байгаа хүмүүсийг явуулаад тэр хүмүүс маань сураад эргэж ирээд дараагийн хүүхдүүдээ бэлддэг, их сургуульд багшилдаг ч юм уу. Дахиад нэг хүнийг бид нар мөнгө өгөөд явуулаад сургагчигсан. Нөгөөдөх нь ирээд 10, 20, 30 хүн бэлддэг. Яг ийм одоо зөв зүйлд энэ нэг тодорхой хэмжээний мөнгөө зориулах ийм шаардлага байгаа. Тэгээд ажлын хэсэгт Найдалаа гишүүн бас орж ажиллана байх гэж бодож байна. Бид нар энийг ер нь яамтайгаа нийлээд одоо нэг зөв болгоод явах нь зүйтэй байх аа.

Дараагийн үг Отгоншарын Батнайрамдал гишүүн хэлнэ.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Сая яах вэ Найдалаа гишүүн бас хэллээ л дээ. Гэхдээ бас Боловсролын зээлийн сан бид нар нөгөө гадаад зээл дээр аягүй их акцент өгөөд тэр нь нөгөө олон нийтэд явчихсан болохоор тэгж бодоод байх шиг байна. Гэхдээ Боловсролын зээлийн сангийн сүүлийн 30 жилийн санхүүжилтийн нийт дүнг нь аваад үзэх юм бол бараг 70 хувь нь дотоодын их дээд сургуульд суралцаж байгаа оюутнууд явсан байдаг юм. Бид нар дотоодын хүүхдүүддээ өгөхгүй байгаа биш өгч байгаа ихэнхийг нь өгч байгаа юм. Нийт сурсан суралцагчийг нь аваад

үзэхээр гадаад зээл нь нийт зардлын 30 хувийг нь авсан мөртөө 3 мянган хүүхдийн асуудал. Дотоод зээл нь энэ чинь би буруу санаагүй бол бараг сая хүүхэд сая суралцагч гэж байдаг байх шүү. Сүүлийн 30 жил маш олон суралцагчид дотооддоо зээл олгосон. Хамгийн том асуудал нь хоорондын тийм ялгавартай үзүүлэлт байгаа юм л даа. Сая Загджав дарга бас зөвлөмждөө унших шиг боллоо. Тэр аягүй ноцтой л доо. Энэ дотоод зээл, дунджаар нэг хүүхэд 4 сая төгрөг л авч байгаа юм л даа. Тэгээд 4 жилийн хугацаанд 16 сая төгрөг. Тэгээд тэр хүүхэд зээлээ буцааж төлөхгүй болохоор Монголбанкны хар жагсаалтад оруулна. Дипломыг нь хураана. Өнөөдөр Боловсролын зээлийн сан дээр бараг 15 мянган диплом хураалттай байгаа шүү дээ. Тэр хүүхдүүдийн дипломыг нь хураачихаар тэр хүүхдийг яаж мэргэжлээрээ ажил хийх гээд байгаа юм. Яаж буцааж зээлээ төлөх гээд байгаа юм. Дотоодын олгосон зээлдээ тэгж ялгавартай хандчихаад гадаад зээлд өгсөн тэр 3 мянган хүүхэдтэй бол эргэж төлөхгүй бол холбогддог ч үгүй ардаас нь хэн ч хөөцөлдөөгүй л явж ирсэн байхгүй юу. Монголбанкны хар жагсаалтад ч, хар жагсаал ч юу байх вэ дээ тэр мэдээллийн зээлийн санд ч ордоггүй байсан. Сая Загджав дарга зөвлөмждөө бас тэр уул нь шийдвэр гарсан гэж ойлгосон. Нэг ёсондоо гадаад зээл авсан, боловсролын сангийн зээл авсан оюутан эргэж төлөөгүй бол одоо Монголбанкны зээлийн жагсаалтад яг нөгөө дотоодын зээл авсан хүүхдүүд шигээ л орох ёстой. Энэ өөрөө шударга ёс шүү дээ. Шударга хандаж байгаа хандлага. Гэтэл энэ нь бас ороогүй байна энийгээ оруулаарай гэж сая зөвлөмждөө Загджав дарга уншиж байх шиг байна л даа.

Тэгэхээр би тэрэн дээр жоохон гайхчихлаа. Яагаад одоо хүртэл шийдвэр нь гарчихсан боловч ороогүй

байгаа юм болоо? Энэ дээр Боловсролын яам уг нь бол үүрэг нь тэр мэдээллээ Монголбанканд өгөх ёстой. Тэрнээс биш Монголбанк ардаас нь хөөцөлдөж тэр мэдээллийг нь авах биш. Аливаа тэр төрийн байгууллага нь өөрөө мэдээллээд Монголбанканд өгснөөр Монголбанк тэрийг зээлийн нийт мэдээллийн сандаа оруулдаг. Тэгэхээр одоог хүртэл Боловсролын яамнаас гадаад тэр зээлийн авсан мэдээллийг одоо нэг ёсондоо зээлээ эргэж төлөөд төлсөн мэдээллийг өгөөгүй л байна гэсэн үг л дээ. Тэгэхээр одоог хүртэл бид нар энэ ялгавартай хандаж ирсэн нь өөрөө яг үнэнийг хэлэхэд олон нийтийн бухимдлыг хамгийн их төрүүлээд байгаа байхгүй юу. Дотоод зээл авсан оюутнууд одоо маш олноороо орсон шүү дээ. Тэгээд тэр хүмүүсийн амьдралд шууд нөлөөлнө. Монголбанкны зээлийн жагсаалтад тэр одоо саарал жагсаалт гэж бид нар ярьдаг. Тэнд орохоор яадаг билээ. Одоо тэр Боловсролын зээлийн сан дээр хураачихсан байгаа тэр 15 мянган дипломыг бас яах вэ гэдгийг бас Наранбаяр сайд бид нар бүгдээрээ шийдэх ёстой шүү. Тэр дипломыг хураагаад одоо яах гэж байгаа юм. Шийдэл байхгүй. Тэгээд нөгөө зээлээ төлөөгүй хураачихсан. Тэгэхдээ гадаад зээл авсан хүний ардаас нэг ч хүн хөөцөлдөж байгаагүй. Сая энэ аудитын дүгнэлт дээр байна шүү дээ. 147 суралцагч холбогдож чадаагүй 10 тэрбум төгрөгийн авлага холбогдож чадахгүй байна. Холбогдож чадахгүй байна гэдэг чинь Монголд байхгүй л байхгүй юу. Тэр холбогдох гэж байгааг нь тэр хүмүүс гадаадад мэдэх ч үгүй явна.

Тэгэхээр ерөөсөө хэн ч хөөцөлдөөгүй одоо явсаар ингээд 20 жил ирчихсэн нэг ийм бугширсан л асуудал байгаа юм л даа. Тэр ялгавартай ханддаг асуудал бол үнэхээр ноцтой шүү. Дотоод сургуульд сурч байгаа хэдэн хүүхдүүдээ дарамталсан мөртөө

гадаадад дандаа эрх мэдэлд нь мэдээллийн ойрхон хүмүүсийн хүүхдүүдийн ардаас хэн ч хөөцөлдөөгүй энэ ялгавартай хандлага л яг үнэнийг хэлэхэд яг олон нийтийн дургүйцлийг хамгийн их хүргэж байгаа юм. Тэгэхээр энийг бас бид нар давхар шийдэх ёстой. Монголбанканд тэр мэдээллийг нь Боловсролын яамнаас жил болгон заавал хуулийнхаа дагуу журмынхаа дагуу өгөх ёстой шүү л гэж хэлмээр.

**Ч.Ундрам:** Боловсролын яам Батнайрамдал гишүүний сая хэлсэн асуудалд анхаараарай. Дараагийн үг Жанчивын Галбадрах гишүүн хэлнэ.

**Ж.Галбадрах:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Түрүүн бас асуулт асуух гээд амжсангүй. Тэгэхдээ хамгийн эхлээд бол энэ аудитын дүгнэлттэй холбоотой саналаа хэлье. Нэлээн олон зөрчил юунууд их гарч байна. Тэгээд энэ бүгдийн тэр зөрчлийг одоо арилгаад арилгах талаар ямар арга хэмжээ авдаг юм. Түрүүн Рэгдэл гишүүн асууцхсан. Зүгээр энэ талын мэдээллийг бас бид нарт бас эргээд өгч байвал их сайн байна. Ямар хугацаанд яаж өгдөг юм бол доо гэдгийг бас сонирхож байгаа. Тэгээд энэ дүгнэлтийг авч харьцуулж харахыг бол хүсэж байна. Дараагийн юм нь хүмүүс маань энэ боловсролын зээлийн сантай холбоотой юм яриад байна. Тэгэхээр энэ зээлийн санг бол би бол одоо гадаадад явах талаар бол хүмүүс зөндөө ярьчихлаа. Би энэ дотоодын зээлийн сан дээр бүүр онцгой эрэлттэй мэргэжил жишээлбэл одоо багш байж байна. Одоо хөдөө орон нутагт бол энэ байгалийн ухааны багш нар ер нь ингээд ховордчихсон. Тэгээд ер нь л улс даяараа багш дутагдалтай байж байна. Хотод ч гэсэн маш их дутагдалтай байна. Одоо ямар үзэгдэл үүсэж байна гэвэл би зүгээр байгалийн ухаан гэсэн дээрээ ярихад хими,

физикийн багш байхгүй байна. Тэгэхээр тэнд инженер гарахгүй байна. Бүүр тэр байтугай эмчээр элсэлтийн ерөнхий шалгалтыг химээр өгдөг хүүхэд байхгүй. Тэгээд химээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөхгүй юм бол анагаахад ордог хүүхэд байхгүй. Анагаахад ордог хүүхэд байхгүй бол буцаад тэр сумд эмч болдоггүй эмч болох хүүхэд байхгүй гэсэн үг. Сумын хүүхэд ер нь сумдаа л ирж эмч болж байгаа. Тэгээд ингээд эмчгүй сумууд бол бас Монгол Улсад нэлээн гараад ирчихсэн. Тэгэхээр энэ хэрэгцээтэй энэ одоо тэр суманд зайлиггүй эмч болох шаардлага байгаад байна. Бид нар одоо энэнээс хойш одоо нэлээн төсөл хөтөлбөрүүд хийнэ, хэрэгжүүлнэ. Шилдэг төгсөгч нь төрөлх сургуульдаа ирж багшилдаг. Тэр дотроо бүүр химийн багш болоод ирье ээ гэдэг ийм төсөл хийхэд энд одоо зориулагдсан энэ тэтгэлэг маань бас зориулагдаж явах ёстой ингэж байгаа олоод тэгээд тэр хүүхэд маань Боловсролын зээлийн сангаар дотооддоо сурчхаад буцаж ирээд ажиллахад нэг 5 жил ажиллалаа гэхэд тэр хүүхдийн төлбөр нь хөнгөлөгдөж байдаг, зээл нь хөнгөлөгдөж байдаг ийм юмыг хийх хэрэгтэй гэж ингэж бодож байна.

Тэгэхээр зээлтэй холбоотой, зээлийн сантай холбоотой ийм юм байж байна. Мөн энэ дээр эмч нар байж байна. Инженер байж байна. Энэ хүмүүст бас бид нар өгөх ёстой. Дараагийн нэг зүйл болохоор ер нь энэ Боловсролын яам, Соёлын яам ингээд байж байна спортын байгууллагууд байж байна. Энд ингээд зарах төсөв маань бол төсөв ингээд өөрөө тэлж байхад өмнө нь эзэлж байсан ДНБ-д эзэлж байсан одоо төсвийн жилийн зардалд эзэлж байсан тэр хувийг одоо бууруулахгүй байх талаар ингэж явах ёстой. Өөрөөр хэлбэл сургууль суралцдаг байгууллага, суралцдаг сургууль тэр байгууллагаараа хөгжиж



явдаг. Сая бас хэлж байна. Найдалаа гишүүн хэлсэн. Энэ сургуулиудыг одоо бид нар гадаадад ингээд үр дүнг баахан зарлахаас илүү дотоодын сургуулиудаа хүчтэй болгох бүүр ЕБС, сургуулийн өмнөх цэцэрлэгийг одоо бид нар бас хүчтэй хөгжүүлэх тал дээр ийм зүгээр нэг барилга бариад өнгөрчихдөг багшийн тэр цалин нийгмийн даатгал нь л өнгөрөөд л одоо боловсролын сайдын төсвийг харахад ердөө тэгээд л өнгөрчихдөг юм байна лээ.

Тэгэхээр энэ хүнээ хөгжүүлэх, тэнд байгаа багш нараа хөгжүүлэх тал дээр бид нар бас анхаарах, ялангуяа одоо энэнтэй холбоотой стандарт мөрдүүлэх, нэг ангид байх хүүхдийн тоог багасгана ч гэдэг юм уу. Багш болгон ширээ сандалтай байна ч гэдэг юм уу. Тэгээд энэ бүгдэд бол ийм хөрөнгө мөнгө маш их шаардлагатай байгаа. Тэгэхээр бид нар тэр стандарт журмуудыг тогтоогоод тэгээд хүний нөөц нь хангалттай болж ирсэн үед бид нар энэ сургууль гэдэг энэ орчныг доторх орчин, доторх тэр багшийн чанарыг дээшлүүлэх тал дээр бид нар бас хөрөнгө мөнгийг их төлөвлөх хэрэгтэй. Тэгэхээр энэ тал дээр одоо Сангийн яамыг би бас уян хатан байж одоо Боловсролын яам бусад Соёлын яамнаас тавьж байгаа энэ юмнуудыг бас анхаарч ажиллаж байхгүй бол нэгэнт л шийдсэн бол шийдсэн гээд ингээд зогсоод байдаг бас тал ажиглагддаг юм байна лээ. Ийм зүйлүүдийг бас хэлье ээ. Ингээд та бүхэнд амжилт хүсье.

**Ч.Ундрэм:** Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь

хэлэлцүүлгийг явуулсан талаар БСШУС-ын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улс Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

БСШУС-ын Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

13.28 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА